



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/560

Есөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр", "Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөр"-ийг олон нийтэд сурталчлах зорилгоор "Зөв мэдээлэл холбоо НҮТББ"-ын дэргэдэх Zuv.mn сайттай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т шилжүүлж, зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 10.000.000 (арван есөн сая) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 20²⁴ оны
09 дугаар сарын 18 ны өдрийн
АБ60 дугаар захирамжийн хавсралт

"БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР", "ГАЗАР
ТАРИАЛАН, ЖИМС ЖИМСГЭНЭ ХӨТӨЛБӨР"- ИЙГ
ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1.	Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр", "Газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөр"- ийг олон нийтэд сурталчлах	10.000.000 төгрөг